



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төвийн данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/645 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 14,700,000.00 (арван дөрвөн сая долоон зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэх өртөггүй Истана маркийн 54-18 УНЦ улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төв (Г.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төв (Г.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т тус тус даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



.. התאחדות חיי השואה (התאחדות חיי השואה) - התאחדות חיי השואה (התאחדות חיי השואה) ..
התאחדות חיי השואה (התאחדות חיי השואה) . התאחדות חיי השואה (התאחדות חיי השואה) ..
התאחדות חיי השואה (התאחדות חיי השואה) ..